



ДОРНОД АЙМГИЙН ОНЦГОЙ КОМИССЫН  
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

2021 оны 06 дугаар сарын 30 өдөр

Дугаар 63

Хэрлэн сум

LXIII ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

Аймгийн Онцгой комиссын 63 дугаар хуралдаан 2021 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн 10:00 цагт цахимаар 100 хувийн ирцтэй хуралдав.

Хуралдааныг аймгийн Засаг дарга, Онцгой комиссын дарга М.Бадамсүрэн даргалж холбогдох үүрэг даалгаврыг өгөв.

СОНССОН НЬ:

1.Аймгийн Онцгой комиссын "Зорчигч тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг хязгаарлах тухай" 85 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх хугацааг сунгах эсэх, сумдын Онцгой комиссоос ирүүлсэн саналыг танилцуулах,

*Аймгийн Засаг даргын Тамгын газар*

2.Аймаг болон сумдын баяр наадмыг тэмдэглэх эсэх талаар хэлэлцэх,

*Аймгийн Засаг даргын Тамгын газар*

3.Улсын баяр наадам болохтой холбогдуулан оролцсон уяач, сур болон шагайн харваач, бөхчүүдийн буцаж ирэхэд тусгаарлалт ажиглалтад хяналт тавих талаар санал танилцуулах,

*Аймгийн Засаг даргын Тамгын газар*

2.Хэрлэн, Хөлөнбуйр сумд болон алслагдсан сумдын хяналтын цэгийн үйл ажиллагааг үргэлжлүүлэн ажиллуулах эсэх талаар хэлэлцэх,

*Бүсийн төв аймгийн Онцгой байдлын газар*

ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

Нэг.Бүсийн төв аймгийн Онцгой байдлын газрын дарга, Онцгой комиссын орлогч дарга, хурандаа Г.Нармандах,

Цагдаагийн газрын дарга, Онцгой комиссын гишүүн

цагдаагийн хурандаа Т.Ганзориг,

Эрүүл мэндийн газрын дарга, Онцгой комиссын

гишүүн Ч.Оюунаа,

Сумын Засаг дарга, Онцгой комиссын дарга нарт:

1.1.Аймгийн хэмжээнд коронавируст халдварын тархалт нэмэгдсэн болон сумдын Онцгой комиссоос ирүүлсэн саналын дагуу хот, аймаг, сум хоорондын зорчигч, тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг 2021 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс мөн оны 07 дугаар сарын 10-ны өдрийг дуустал түр хязгаарлах тухай аймгийн Онцгой комиссын тогтоолын төсөлд гишүүдийн саналыг тусгаж батлуулах,

 / М.Бадамсүрэн  
 /Хур Г.Нармандах

Хоёр.Аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга,  
Онцгой комиссын гишүүн П.Бат-Өлзий-д:

2.1.Аймгийн хэмжээнд коронавируст халдварын тархалт нэмэгдэж эх уурхай тогтоогдоогүй тохиолдлууд гарч байгаа тул аймаг болон сумдын баяр наадмыг тэмдэглэхгүй байх тухай аймгийн Онцгой комиссын тогтоол гаргах,

Аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга,  
Онцгой комиссын гишүүн П.Бат-Өлзий,  
Цагдаагийн газрын дарга, Онцгой комиссын гишүүн  
цагдаагийн хурандаа Т.Ганзориг,  
Эрүүл мэндийн газрын дарга, Онцгой комиссын  
гишүүн Ч.Оюунаа,  
Сумын Засаг дарга, Онцгой комиссын дарга нарт:

2.2.Аймгийн хэмжээнд Коронавируст халдвар /Ковид-19/-ын тархалт нэмэгдэж эх уурхай тогтоогдоогүй тохиолдлууд гарч байгаа тул аймаг болон сумдын баяр наадмыг тэмдэглэхгүй байхад хяналт тавьж ажиллах,

Аймгийн Засаг даргын орлогч, Онцгой комиссын  
гишүүн Ш.Ёл-д:

2.3.Улсын баяр наадамд оролцох хүсэлт гаргасан уяач, сур болон шагайн харваач, бөхчүүдийг харьяалагдах холбоонуудтай холбогдож тоо зааж бүртгэн Улаанбаатар хот руу зорчуулах эсэх талаар аймгийн Шуурхай штабын хуралд танилцуулах,

2.4.Олон нийтэд хүргэх зорилгоор баяр наадмын тухай контент хийх ажлыг зохион байгуулах,

2.5.Үндэсний баяр наадмын салбар хороонд Дорнод аймгийн хэмжээнд баяр наадам зохион байгуулахгүй тухай аймгийн Онцгой комиссоос албан бичиг хүргүүлэх,



АЗДТГ-ын Олон нийттэй харилцах албаны дарга,  
Онцгой комиссын гишүүн Э.Батболд-д:

2.6.Баяр наадам тэмдэглэх эсэх талаар олон нийтээс цахимаар санал асуулга авч танилцуулах,

Эрүүл мэндийн газрын дарга, Онцгой комиссын  
гишүүн Ч.Оюунаа,  
Аймгийн ерөнхий тархвар судлаач эмч, Онцгой комиссын  
гишүүн Б.Ганганцэцэг нарт:

2.7.Аймгийн хэмжээнд эрүүл мэндийн одоогийн нөхцөл байдал, халдварын тархалтын түвшин, эдийн засгийн эрсдэл, эрүүл мэндийн эрсдэлийн үнэлгээг гаргаж олон нийтэд танилцуулах,

Бүсийн төв аймгийн Онцгой байдлын газрын дарга, Онцгой комиссын  
орлогч дарга, хурандаа Г.Нармандах,  
Цагдаагийн газрын дарга, Онцгой комиссын гишүүн  
цагдаагийн хурандаа Т.Ганзориг,

/  / М.Бадамсүрэн  
/  / Хүр Г.Нармандах

Мэргэжлийн хяналтын газрын дарга, Онцгой комиссын гишүүн Д.Мөнхтуяа,  
Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга, Онцгой комиссын гишүүн А.Гантулга,  
Сумын Засаг дарга, Онцгой комиссын дарга нарт:

2.8.Иргэд гэр бүлийн хүрээнээс бусад аялал зугаалгаар явсан тохиолдолд хариуцлага тооцож ажиллах,

Аймгийн Засаг даргын орлогч, Онцгой комиссын гишүүн Ш.Ел,  
Бүсийн төв аймгийн Онцгой байдлын газрын дарга, Онцгой комиссын орлогч дарга, хурандаа Г.Нармандах,  
Эрүүл мэндийн газрын дарга, Онцгой комиссын гишүүн Ч.Оюунаа,  
Мэргэжлийн хяналтын газрын дарга, Онцгой комиссын гишүүн Д.Мөнхтуяа нарт:

2.9.Аймгийн уяач, үндэсний бөх, сур, шагайн холбооны тэргүүнүүдтэй уулзалтыг зохион байгуулах,

2.10.Улсын баяр наадамд оролцсон иргэд буцаж ирээд өөрийн зардлаар тусгаарлах байранд 7 хоног тусгаарлах талаар мэдэгдэх,

2.11.Үндэсний баяр наадмын шагай болон сурын харваа, бөхийн барилдаанд оролцох иргэдийг 20-оос илүүгүй оролцуулах, холбоодын хяналтад цол зэрэгтэй иргэдийг оролцуулах талаар аймгийн Шуурхай штабын хуралд хэлэлцүүлэх, оролцох иргэд дасгалжуулагчгүй оролцох,


Эрүүл мэндийн газрын дарга, Онцгой комиссын гишүүн Ч.Оюунаа-д:

2.12.Баяр наадамд оролцсон иргэдээс авах коронавирусын тестийн бэлэн байдлын нөөцийг хангах,

Бүсийн төв аймгийн Онцгой байдлын газрын дарга, Онцгой комиссын орлогч дарга, хурандаа Г.Нармандах,  
Цагдаагийн газрын дарга, Онцгой комиссын гишүүн цагдаагийн хурандаа Т.Ганзориг,  
Эрүүл мэндийн газрын дарга, Онцгой комиссын гишүүн Ч.Оюунаа,  
Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн захирал, Онцгой комиссын гишүүн Д.Должин нарт:

2.13.Үндэсний баяр наадамд оролцоод ирж буй иргэдээс шинжилгээ авах, тусгаарлах байрны хүн хүчний бэлэн байдлыг хангах,

Бүсийн төв аймгийн Онцгой байдлын газрын дарга, Онцгой комиссын орлогч дарга, хурандаа Г.Нармандах,  
Цагдаагийн газрын дарга, Онцгой комиссын гишүүн цагдаагийн хурандаа Т.Ганзориг нарт:

 / М.Бадамсүрэн  
/ Хур Г.Нармандах

Гурав.АЗДТГ-ын Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга,  
Онцгой комиссын гишүүн Х.Бат-Эрдэнэ,  
Бүсийн төв аймгийн Онцгой байдлын газрын дарга, Онцгой комиссын  
орлогч дарга, хурандаа Г.Нармандах,  
Цагдаагийн газрын дарга, Онцгой комиссын гишүүн  
цагдаагийн хурандаа Т.Ганзориг,  
Хилийн болон Зэвсэгт хүчний ангиудын захирагч,  
Сумын Засаг дарга, Онцгой комиссын дарга нарт:

3.1.Хэрлэн, Хөлөнбуйр сум болон алслагдсан сумдын хяналтын цэгийн үйл ажиллагааг 2021 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс мөн оны 08 дугаар сарын 01-ний өдрийг дуустал хэвийн үргэлжлүүлэх,

АЗДТГ-ын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга,  
Онцгой комиссын гишүүн В.Цэнгэлмаа-д:

3.2.Хэрлэн, Хөлөнбуйр сумд болон алслагдсан сумдын хяналтын цэгт 2021 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс мөн оны 08 дугаар сарын 01-ний өдрийг дуустал ажиллахад гарах зардлыг тооцож аймгийн Засаг даргын зөвлөлийн хуралд танилцуулж шийдвэрлүүлэх,


3.3.“Дулаан” дэн буудал тусгаарлах байранд томилогдон ажиллаж буй олон нийтийн цагдаагийн ажилласан томилолтын зардлыг тооцож аймгийн Засаг даргын зөвлөлийн хуралд танилцуулж шийдвэрлүүлэх,

Аймгийн Онцгой комиссын нийт гишүүд,  
Сумын Засаг дарга, Онцгой комиссын дарга нарт:

3.4.Иргэдээс хүсэлт авч буй 70584647.mn цахим хуудасны ашиглалтыг сайжруулж хэрэглээг нэмэгдүүлэхэд анхаарах,

Бүсийн төв аймгийн Онцгой байдлын газрын дарга, Онцгой комиссын  
орлогч дарга, хурандаа Г.Нармандах,  
Цагдаагийн газрын дарга, Онцгой комиссын гишүүн  
цагдаагийн хурандаа Т.Ганзориг,  
Эрүүл мэндийн газрын дарга, Онцгой комиссын  
гишүүн Ч.Оюунаа,  
Мэргэжлийн хяналтын газрын дарга, Онцгой комиссын  
гишүүн Д.Мөнхтуяа,  
Сумын Засаг дарга, Онцгой комиссын дарга нарт:

3.5.Аймаг сумын Онцгой комиссын шийдвэрээр томилогдон ажиллаж буй албан хаагч нарт халдвар хамгааллын дэглэмийг мөрдүүлэх талаар зөвлөж анхаарал хандуулж ажиллахыг тус тус үүрэг болгов.

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА, ОНЦГОЙ  
КОМИССЫН ДАРГА  М.БАДАМСҮРЭН

АЙМГИЙН ОНЦГОЙ КОМИССЫН ОРЛОГЧ  
ДАРГА, ХУРАНДАА  Г.НАРМАНДАХ